

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс  
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,  
Утас: 7012-1530, 7012-1529  
И-мэйл: info@golomtcapital.com,  
Вэбсайт: www.golomtcapital.com

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН  
БИРЖ”-Д

2021. 10. 25. № 21/242  
-ны № \_\_\_\_\_ Т

**Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын  
төлөвлөгөөг хүргүүлэх тухай**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“Голомт Капитал ҮЦК” ХХК нь “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох үйл ажиллагааны Үндсэн андеррайтераар ажиллаж байгаа билээ. Тус хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэл буюу ажлын 5 өдрийн дотор зохион байгуулах төлөвлөгөөг 21/236 тоот албан бичгээр та бүхэнд өмнө хүргүүлсэн.

Тус үйл ажиллагааны хүрээнд “Голомт Капитал ҮЦК” ХХК нь анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг Хавсралтаар хүргүүлж буйг хүлээн авна уу. Үүнд “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК болон “Премиум” Группийн харьяа компаниудын ажилтнуудын захиалгыг 6 сарын хугацаанд хувьцааг тусгаарлах нөхцөлтэйгээр бүрэн биелүүлж, жижиглэнгийн хөрөнгө оруулагчийн хуваарилалтад оруулах саналтай байгаа тул та бүхэн шийдвэрлэж өгнө үү. Хувьцааг тусгаарлах нөхцөлтэй захиалгыг нэмэгдүүлснээр хувьцааны үнийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Хүндэтгэсэн,  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С. ГАН-ЭРДЭНЭ



**“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн хувьцааг анхдагч зах зээлд  
арилжих төлөвлөгөө**

**Үнэт цаасны товч танилцуулга**

	<b>Green shoe-гүй</b>	<b>Green shoe-тэй</b>
Нийтэд санал болгож буй хувьцааны тоо ширхэг	119,966,060	137,960,969
Татан төвлөрүүлэх дүн	24,952,940,480 төгрөг	28,695,881,552 төгрөг
Нэгж хувьцааны үнэ	208 төгрөг	
Анхдагч зах зээлийн арилжааны арга	Тогтоосон үнийн арга	
Захиалга авах хугацаа	2021.10.29-11.04	
Хуваарилалт	Монголын Хөрөнгийн Бирж	

**Стратегийн хөрөнгө оруулагчдын хуваарилалт**

	<b>Green shoe-гүй</b>	<b>Green shoe-тэй</b>
Санал болгож буй хувьцааны тоо ширхэг	59,983,030	77,977,939
Татан төвлөрүүлэх дүн	12,476,470,240 төгрөг	16,219,411,312 төгрөг

Дараах нөхцөлийг хангасан хөрөнгө оруулагчдыг стратегийн хөрөнгө оруулагчид тооцно. Үүнд:

Хөрөнгө оруулалтын үнийн дүн	100,000,000 төгрөг болон түүнээс дээш
Хувьцаа тусгаарлах хугацаа	6 сар болон түүнээс дээш

1. "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК, "Апекс Капитал ҮЦК" ХХК-тай хувьцаа худалдан авахаар урьдчилсан захиалгын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид;
2. "Голомт Капитал ҮЦК" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан Үнэт цаасны компаниудын хөрөнгө оруулагчид

**Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын хуваарилалт**

Санал болгож буй хувьцааны тоо ширхэг	59,983,030
Татан төвлөрүүлэх дүн	12,476,470,240 төгрөг

Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад дараах нөхцөл тавигдана. Үүнд:

1. Захиалгын үнийн дүнд хязгаарлалтгүй, хувьцааг тусгаарлахгүй. Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын 208,000 төгрөг буюу 1000 ширхэг хүртэлх хувьцааны захиалга бүрэн биелнэ. Түүнээс дээш дүнг хувь тэнцүүлнэ.
2. "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК болон "Премиум" Группийн охин компаниудын ажилтнуудын хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлана. Тус хөрөнгө оруулагчдын хувьцааны захиалга бүрэн биелнэ. Хувьцааг тусгаарлахгүй ажилтнуудын захиалгыг хувь тэнцүүлнэ.

